



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 06/01

Улаан-уул


Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх заалтууд, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 6 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий 5 (тав) төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийг байгуулан хавсралтаар баталсугай.

2. Хурлын хороодын тасралтгүй үйл ажиллагааг хангаж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын жилийн эцсийн хуралдаанд тайлагнахыг Зөвлөлийн дарга(С.Гонгор)-т үүрэг болгосугай.


ДАРГА  С.ГОНГОР



Ёсчилсон 2022 оны 03 сарын 10 ны өдөр

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
6 дугаар хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 10-ны
өдрийн 06/01 дүгээр тогтоолын хавсралт

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Зөвлөлийн дарга: С.Гонгор –Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Гишүүдэд: Ц.Элбэгбаяр – Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Х.Одгэрэл – Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Г.Нямдаваа – Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

А.Мөнхцэцэг – Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

---oO---